Платформын удирдах хорооны хурлын тэмдэглэл

Нэр: Монголын Тогтвортой Ноолуурын Платформ

Байршил: НҮБ-ын байр, 6-р давхрын хурлын танхим

Огноо: 2020 оны 5-р сарын 26-ны өдөр

Хурал удирдсан: Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч

Хурал хамтран удирдсан: Х.Хишигжаргал, НҮБХХ-ын Хөтөлбөрийн Шинжээч

Оролцогчид: Ирц – оролцвол зохих 8 хүнээс 7 буюу 87.5%

№	**Төслийн удирдах хорооны гишүүд**	**Гишүүн бус**
Оролцсон	1. Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч	9. Х.Хишигжаргал, НҮБХХ-ийн шинжээч 10. В.Шинэнэмэх, Менежер, Монголын Тогтвортой Ноолуурын Платформ төсөл 11. Д.Баярмаа, Санхүү, Захиргааны ажилтан Монголын Тогтвортой Ноолуурын Платформ төсөл
	2. А.Амгалан, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Техникийн зөвлөх	
	3. Ц.Эрдэнэбат, Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Эдийн засаг, аж үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх	
	4. Т.Булган, БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	
	5. Д.Алтанцэцэг, Монголын Ноос Ноолуурын Холбооны гүйцэтгэх захирал	
	6. Н.Ганхуяг, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооний гүйцэтгэх захирал	
	7. Б.Батхишиг, Зөвлөх хорооны төлөөлөл	
Оролцоогүй	1. Б.Батхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга	

1. **Удирдах хорооны хурлаас гарах үр дүн:**

- Удирдах хорооны ажлын удирдамжийг батлах;
- Өнөөг хүртэл хийгдсэн ажлын танилцуулга;
- МТНП-ын 2020 оны ажлын төлөвлөгөөг батлах;
- Covid-19-ийн нөлөөлөл салбарт, хэлэлцүүлэг ярилцлага, гарц шийдэл

ХӨТӨЛБӨР

Цаг	Арга хэмжээ	Хөтлөгч/илтгэгч
13:00 – 13:20	Өдрийн хоол	
13:20-13:30	Зураг авахуулах	
13:30 – 13:40	Удирдах хорооны хурлын албан ёсны нээлт, танилцуулга	Илейн Конкиевич, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч
13:40 – 13:55	УХ-ны гишүүдийн үүрэг хариуцлага, ажлын удирдамжийг танилцуулж, батлах	В.Шинэнэмэх, Платформын менежер
13:55 – 14:10	МТНП-ыг байгуулах шийдвэр гарснаас хойш хийгдсэн ажил, 2019 оны 6 болон 9-р сард хийгдсэн зөвлөгөөн, замын зураглал, ажиллах зарчим, хамтын удирдлагын талаар	Х.Хишигжаргал, Хөтөлбөрийн шинжээч В.Шинэнэмэх, Платформын менежер
14:10 – 14:40	Covid-19 салбарт үзүүлж байгаа нөлөөлөл, МТНП-ийн хамтын ажиллагааны боломжит чиглэл	Модератор: Илейн Конкиевич
14:40 – 14:55	МТНП-ын 2020 оны ажлын төлөвлөгөөг танилцуулж, батлах	В.Шинэнэмэх, Платформын менежер
14:55 – 15:00	Дүгнэлт болон Хаалт	Илейн Конкиевич, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч

2. Хэлэлцүүлгийн хураангуй

Хурлыг НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч Илейн Конкиевич нээж үг хэлээд, хэлэлцэх асуудлыг танилцуулав. Тэрээр 2019 оны 11 сард Монгол дахь НҮБХХ-ийн суурин төлөөлөгчөөр ажиллахаар томилогдон ирсэн бөгөөд өмнө нь Казакстан зэрэг ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсуудад ажиллаж байсан.

Илейн Конкиевич, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч: МТНП-ын Удирдах Зөвлөлийн Хуралд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, төлөөлөгч та бүхэнд юуны өмнө талархал илэрхийлье! Бидэнтэй урт удаан хугацааны турш идэвхитэй хамтран ажиллаж байсан болон шинээр нэгдэн нийлж буй Эвсэл, Холбоод, Бүлгүүдийн төлөөлөл болсон эрхэм зочдоо хүлээн авч байгаадаа бид туйлын баяртай байна. НҮБХХ Тогтвортой Ноолуурын Платформ байгуулж байгаа нь энэ чиглэлээр ажиллаж байгаа төсөл, санаачлагууд хоорондын уялдааг сайжруулах, хангах, хамтын ажиллагааг дэмжих зорилготой. Хэдийгээр Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хил хаагдаж ноос ноолуурын салбарын бүхий л оролцогч талууд сөрөг нөлөөнд өртөж байгаа ч үүссэн нөхцөл байдлыг хүндрэл, сорил гэж үзэхээс илүүтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, ирээдүйн үйл ажиллагааагаа тогтвортой болгох, худалдаа экспортыг шууд зах зээлд нийлүүлдэг болох, нэмүү өртөг шингээж борлуулдаг болох зэргээр зөв суурийг тавих боломж гэж харахыг хичээх нь зөв гэж бодож байна.

Хөтөлбөрийн дагуу, Платформын менежер В.Шинэнэмэх Удирдах хорооны ажлын удирдамжийг танилцуулав. (Хавсралт 1).

Платформын менежер В.Шинэнэмэх: НҮБХХ-ийн Green Commodities Programme нь Платформ байгуулах загвар, сайн туршлага тал дээр зөвлөж байгаа. Зөвлөмжийн дагуу Удирдах хорооны ажлын удирдамжыг боловсруулсан. Удирдах хорооны бүрэлдэхүүнд 8 байгууллагын төлөөлөл оролцоно. Байгууллага бүрээс үндсэн болон орлох төлөөлөгч томилно. Үндсэн төлөөлөгч хуралд оролцох боломжгүй үед орлох төлөөлөгч оролцоно. Платформын үйл ажиллагаа жигдэрч, тодорхой болтол Удирдах хорооны хурлын даргаар НҮБХХ ажиллана. Цаашдаа платформ бие даах үед гишүүд дотроосоо хурлын дарга, дэд дарга сонгодог болно гэж төлөвлөж байна.

Удирдах хорооны үүрэг хариуцлага:

- Платформын алсын хараа, зорилго зорилтуудыг тодорхойлох, батлах
- Үйл ажиллагааны журам, төлөвлөгөөг батлах,
- Үндэсний хэмжээнд талуудын дунд хэрэгжих арга хэмжээнүүдийн төлөвлөгөөний эцсийн хувилбарыг албан ёсоор баталж платформын хүндэт элчийн үүргийг гүйцэтгэх,
- Чухал эсвэл нөлөөлөл ихтэй талууд, төрийн байгууллагуудын оролцоог хангах,
- Ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжих

Ажлын хэсэг нь шууд удирдах хороондоо тайлагнаж удирдах хорооноос өгсөн чиглэлийн дагуу ажиллана.

- Сайн туршлага, зарчмууд буюу ямарваа нэг шийдвэрт хүрэхдээ аль болох олны саналаар биш зөвшилцлийн зарчмаар явна.

Удирдах хороо улиралд нэг удаа хуралдана. Хурлаас гарсан шийдвэрийг хурлын тэмдэглэлд буулган 1 долоо хоногийн дотор имэйлээр явуулж батлуулж вэб сайт болон бусад мэдээллийн хэрэгслээр нээлттэй тайлагнана. Нээлттэй ил тод зарчмыг бүх шатандаа хэрэгжүүлж ажиллах болно. Платформын үйл ажиллагаанд хэн, яаж, хэрхэн оролцож байгааг нээлттэй мэдээлдэг байна. Та бүхэнд асуулт, санал, зөвлөмж байвал хуваалцана уу?

Т.Булган: Ажлын удирдамжийн төсөлд Удирдах хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын төлөөлөл Сайд, Дэд сайд буюу нэлээн улс төрийн өндөр түвшний албан тушаалтан орно гэсэн байна. Энэ цаанаасаа ингэж

шаарддаг уу, уул нь асуудлаа хариуцаад явж байгаа Бодлогын газрын даргын түвшинд байж болоогүй юу? Мөн энэ төслийн хувьд орон нутгийн оролцоог сайн хангах нь үр дүнтэй гэж бодож байна.

В.Шинэнэмэх: Платформын үндсэн чиг баримт бичиг болох Замын зураглалд, загвар ёсоор Сайд, Дэд сайд гэж тусгагдсан ёсоор танилцуулж байна. Монголын нөхцөлд, ажлаа хариуцаж байгаа газар/хэлтсийн дарга тухайн асуудлаа илүү гүнзгий мэддэг тул газар/хэлтсийн даргын түвшинд удирдах хорооны гишүүдийг бүрдүүлэх нь урт хугацаанд зөв гэж бодож байна. Орон нутгийн оролцоог хангах тал дээр Х.Хишигжаргал тайлбарлах уу?

Илейн Конкиевич: Би эхний асуулт дээр нэмж хариулая. Удирдах хороо нь жилд цөөхөн хуралддаг, дээд түвшний шийдвэр гаргах үүрэгтэй нэгж тул аль болох өндөр түвшний албан тушаалтан гишүүнээр оролцвол дээр гэж үзэж байна, бусад улсад тийм байдаг. Цаашид сайд биш юмаа гэхэд дэд сайдын түвшинд оролцоог хангахын төлөө ажиллавал сайн гэж бодож байна. Монголын нөхцөлд ямар бүтцээр ажиллавал илүү тохирох вэ гэдгийг энэ групт байгаа гишүүд өөрсдөө ярилцаад шийдэх байх.

Т.Булган: БОАЖЯ нь тогтвортой бизнесийн платформ байгуулж ажиллах тал дээр туршлагатай, МБанкныХ-той хамтраад Монголын ТоС хөтөлбөр байгуулахад, бодлогоор дэмжлэг үзүүлж, оролцож хувь нэмэр оруулсан. Онцгой чухал үед, жишээ нь санамж бичиг байгуулах тохиолдолд сайд нар оролцоод, илүү баталгаажуулах түвшинд ажиллаж явсан сайн туршлага бий.

Б.Батхишиг: МБАНХ болон ТННЭ малчдын буюу орон нутгийн байгууллагыг төлөөлж оролцож байна. Платформ байгуулах 2 жилийн төлөвлөгөө ажил болж байгаад баяртай байна.

В.Шинэнэмэх: Ажлын удирдамжтай холбоотой өөр санал байвал хэлээрэй

А.Амгалан: Удирдах хорооны гишүүдэд сайд, дэд сайд байна гэж санал оруулсан байна. Удирдах хорооны уулзалтыг улиралд нэг удаа буюу жилд 4 удаа гэдэг нь хэтэрхий олон санагдаж байна. Ялангуяа сайд, дэд сайдын түвшинд оролцоог хангахад хэцүү болно. Тэгэхээр газрын даргын түвшинд хүмүүс байвал илүү зүгээр байх. Хөдөө аж ахуйн яамны хувьд Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга байвал илүү тохиромжтой санагдаж байна. Удирдах хорооны үүрэг нь стратегийн чиглэлээр хангаж ажиллах болохоор жилд 1 удаа хийх саналтай байна.

В.Шинэнэмэх: Саналыг хүлээн авлаа.

Н.Ганхуяг: Манай байгууллага бол малчдын байгууллагын төлөөлөл мөн, анх төслийн дизайн хийгдэж байхаас малчид, малчдын байгууллага, хоршоодыг төлөөлүүлэхээр болсон. Бүтэц зохион байгуулалтын хувьд 18 аймагт аймгийн БАХ, 150 суманд сумын БАХ, 1500 орчим малчдын хэсэгт 80 мянган орчим малчин өрх харьяалагддаг, мөн 80 суманд анхан шатны хоршоо, аймгийн дундын хоршоод байгуулагдсан. 2015 онд эдгээр хоршоод шүхэр байгууллага болгож Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоог үүсгэсэн, УЗ дарга нь Завханд байдаг, Гүйцэтгэх захирал нь оролцож байна.

Д.Алтанцэцэг: Удирдах хороог харин ч цаг үеийн байдлаас шалтгаалан хуралдуулах шаардлагатай гэж бодож байна. Яагаад гэвэл Ноолуурын салбар бол 3-6 сарын хооронд бэлтгэлийн идэвхтэй байдаг үе юм. 100 гаруй аж ахуйн нэгж нэгтгэсэн мэргэжлийн холбоо. Платформ цаг үеэ олсон гэж үзэж байна. Хамтын ажиллагааны механизм зөвшилцөл мөн.

В.Шинэнэмэх: Санал хэлсэн бүх гишүүддээ баярлалаа. Саяны гарсан саналуудыг тусгаад удирдамжийн эцсийн хувилбарыг хорооны гишүүддээ имэйлээр явуулж 7 хоногийн дотор эцэслэн батлах шаардлагатай. Тийм болохоор та бүхэн дэмжиж байна, баталж байна гэж саналаа өгөөрэй. Хөтөлбөрийн дагуу дараагийн асуудалд ороё.

Илейн Конкиевич: Тодотгол хэлье. Удирдах хороо ойр ойрхон хуралдах үүрэгтэй нэгж биш гэж бодож байна. Миний туршлагаар жилд 1 удаа хуралддаг практик байна, жишээ нь жилийн төлөвлөгөө батлах зорилгоор буюу дээд түвшний шийдвэр гаргах нь гол үүрэг. Харин илүү техник асуудлаар, ойрхон уулзах шаардлагатай гэвэл Зөвлөх хороо болон бусад нэгжүүд байж болно. Шийдвэр гаргах, техник асуудлаар уулзах 2-ыг салгаж ойлгоорой.

Х.Хишигжаргал: Та бүхэнд нэг тодруулга хийе. Удирдах хороо нь Зөвлөх хорооноос ондоо төлөөлөл орсон. Тийм учраас зөвлөх хорооны гишүүд нь хийж буй үйл ажиллагаагаа засгийн газрын бусад төлөөлөлд хүргэх боломжгүй учраас яамны удирдах шатны төлөө хамрах шийдвэр гаргах шаардлагатай тохиолдолд удирдах хороо нь зайлшгүй хэрэгтэй. Зөвлөх хороо нь 4 хэрэгжүүлж байгаа төслүүдээс бүрдсэн бөгөөд байгуулагдсан зорилго нь одоо хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааг бид нар платформын хийж байгаа тогтвортой гэсэн тодорхойлолтыг илүү тодорхой болгоход зөвлөх үүрэгтэй байгаа.

В.Шинэнэмэх: Төслийн ажлын явц, цаашдын төлөвлөгөө, бүтэц засаглал, удирдлага зохион байгуулалт сэдэвт презентаци танилцуулья (Хавсралт 2).

Х. Хишигжаргал өмнөх онуудад хийсэн ажлуудыг танилцууллаа.

В.Шинэнэмэх: Презентаци танилцуулав.

Илейн Конкиевич: Covid-19 салбарт үзүүлж байгаа нөлөөлөллийн талаар ярилцая. Одоогийн нөхцөл байдал салбарт, малчдад яаж нөлөөлж байгаа, хэрхэн резилиент болох талаар, мөн ямар үйлдэл, арга хэмжээ авч байгаа тухай хэлэлцэх саналтай байна. UNDP энэ талаар судалгаа явуулсан.

Б.Батхишиг: ТННЭ нь “SFA COVID-19 Action Plan” стратеги, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж байгаа. Олон улсын зах зээлд нөлөөтэй гишүүд болон хамтрагч талуудыг энэ төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаанд оролцох тал дээр уриалж байгаа бөгөөд өөрсдийн supply chain буюу бэлтгэлийнхээ тогтолцоондоо эдгээр ажлуудыг тусгахад эвслийн зүгээс дэмжин хэрэгжүүлэх арга замуудыг заасан болно. Энэ төлөвлөгөө салбарын хувьд үндэсний ба олон улсын өмнө тулгарч буй асуудлуудыг тодорхойлоход чиглэсэн бөгөөд малчид, хоршоологчид, үйлдвэрлэгч, брэндүүд оролцуулсан судалгаа, ярилцлага явуулсан. Малчид, үйлдвэрлэгч 1. Банкны зээл эргэн төлөх, 2. Оюутны төлбөр төлөх, 3. Малын өвс тэжээл, мал эмнэлэг, өвөлжилтөд бэлтгэх зэрэг эрсдлийг давах байдлыг хангах гэсэн асуудлаар хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна. Үүндээр үндэслэн “SFA COVID-19 Action Plan” хүрээнд хариу арга хэмжээг дараах 3 түвшинд боловсруулж байгаа, 6/15 гэхэд эцсийн тайлан, үр дүн гарна: 1) малчид, хоршоологчдын амьжиргааг алдагдуулж болзошгүй эрслийг тооцож, тэднийг оновчтой дасан зохицох чадамжинд анхаарах, 2) эвслийн ноолуур бэлтгэл ба үйлдвэрлэлийн стандартын хэрэглээг хөгжүүлж, энэ давуу байдлаар ноолуурын зах зээлийн эрэлт ба өртгийг нэмэгдүүлэх, 3) нэгдмэл зорилгын хүрээнд уялдаа ба хамтын ажиллагаанд оролцох. “SFA COVID-19 Action Plan”тайлан эвслийн гишүүдээр хэлэлцээд эцэслэхэд хуваалцана.

Д.Алтанцэцэг: Үйлдвэрлэгч, ЖДҮ-ийн хувьд эдийн засгийн хувьд их сөрөг нөлөөлөлтэй жил өрнөж байна. Экспортын гэрээ цуцлагдсан нь ноолуурын салбарын хувьд сул зогсолттой жил болж байна. Түүхий эдийн үнэ үйлдвэрлэсэн бүтээгдхүүний өртөгөөс давсан тул энэ салбар дампуурах нөхцөл бүрдээд байна. 5 сарын 11-нд хөнгөлөлттэй ноолуурын нөхцөл батлагдсан. Төрөөс гарсан энэ 1 удаагийн арга хэмжээ нь үйлдвэрлэгч, малчдыг аль алинийг хохируулах шийдвэр боллоо. Төр бол бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд шууд оролцохоос татгалзах хэрэгтэй. Тиймээс урт хугацааны туршид төрөөс явуулж байгаа арга хэмжээ, үйлдвэрт ажиллаж байгаа ажиллагсдын ажлын байрыг яаж хамгаалах вэ? Цаашлаад иргэдийн амьжиргааг яаж хангах, ажлын байр яаж хадгалах бэ? гэсэн асуудалд анхаарах хэрэгтэй. Ноолуурын салбарт ажиллаж буй хүмүүсийн 85% нь эмэгтэйчүүд байна тэгэхээр энэ жижиг дунд үйлдэрлэл эрхлэгч нарт үүсээд байгаа хүндрэл нөхцөл байдлаас яаж бизнесийн төлөвлөгөөг уян хатан байлгаж өөрчилж ажиллах вэ? асуудлаар 6 удаагийн цуврал хичээл зохион байгуулсан. Төрөөс хүсэх зүйл бол халамжийг өгөх бус урт хугацааны үйлдвэрлэлийг яаж хадгалж, дэмжих вэ гэсэн асуудалд онцгой анхаараасай гэж хүсэж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдхүүний борлуулалтыг яаж хийх талаар төр анхаарч дэмжинэ үү. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрүүдтэйгээ хамтарсан уулзалт, сургалтууд хийхээр төлөвлөж байна.

Ц.Эрдэнэбат: Платформ зохион байгуулалтанд орж байгаад баяртай байна. Action plan-д санал оруулах хүсэлтэй байна. Төслийн хүрэх үр дүн нь тодорхой, KPI хэмжигдэхүйц байвал сайн. Төр ямар үед яаж оролцох вэ гэдэг нь тодорхой байвал их зүгээр байдаг, 30 жил зах зээлд орхисноор алдсан зүйлс бий. Гадаад зах зээл дээр дэмжлэг үзүүлэх тал дээр Ерөнхийлөгчийн зүгээс нэлээн хэдэн зах зээлийг нээх тал дээр ажиллаж байна. Ковидтой холбоотой асуудлаар 10 минутад яриад багтахгүй, ЕТГ-с олон ажлууд хийгдэж

байна. Ноолуурын асуудлаар маш сайн мэдээллийн баазтай болох шаардлагатай байна. Хурд, зөв шийдвэр гаргахын тулд дата дээр тулгуурлаж, бүх салбарынхан ижил мэдээлэлтэй байж, шийдвэр гаргах боломжтой болно. Action plan-аа явуулчихвал би өөрийн зүгээс нэмэх ажлуудыг нэмье.

Н.Ганхуяг: Малчид түүхий эд нийлүүлэх хүсэлт ирүүлсэн ч үйлдвэрлэгчдээс захиалга ирээгүй, ойрын 3-4 сард амьжиргаа дордох эрсдэлтэй байна. Зээл тэглэсэн шийд, арьс шир, ноосны урамшуулал малчдын амьдралд дэм болж байна. Ноолуур хүнд байгаа ч торомны ноос, сарлагын хөөврийн үнэ тогтвортой (7-8 мянга), орлогын эх үүсвэр болж байна. Мөн гуравдагч, гадаадаас шууд захилга авсан малчид ноолуураа борлуулж чадаад байна, хэд хэдэн байгууллагын жишээ харлаа, санхүүжилт орсон. Цаашдаа ингэж борлуулах, Платформ үүнд дэм болох байх гэж найдаж байна.

Т.Булган: ОУ-ын байгууллагын дэмжлэгтэй ажиллаж байх хугацаандаа Платформ цаашдаа бие даах чадвартай болох нь чухал, энэ тал дээр анхаарах хэрэгтэй. Судалгаа хийхдээ шалгуур, хэмжигдэхүйц, тодорхой байдлыг хангаад явбал үр дүнд хүрэх байх. БОАЖЯ-ны зүгээс хэлэхэд зөвхөн түүхий эд бэлтгэлээс гадна үйлдвэрлэлийн шатанд тогтвортой, бохирдуулахгүй байхыг том зургаар харж, анхаарч авахыг хүсье.

А.Амгалан: НҮБ-ын ХХААБ-аас Ковид 19 хүнс хөдөө аж ахуйн салбарт яаж нөлөөлж буйг судалсан бөгөөд ноолуур манай судалгааны жижиг хэсгийг бүрдүүлсэн. Дүгнээд хэлэхэд дандаа сөрөг үр нөлөөлөл гараагүй гэдэг нь тогтоогдсон, жишээ нь хүнсний үйлдвэрлэгчдийн захилга нэмэгдсэн байна. Судалгааны тайланг хуваалцья.

Б.Батхишиг: Манай гишүүн худалдан авагчид (дэлхийн ноолуур худалдан авалтын 80 орчим хувийг хийдэг 100 гаруй брэнд) тогтвортой арга ажиллагаа ба зохистой дадлыг хэрэгжүүлж буй менежментийг хангасан баталгаажсан ноолуур худалдан авах сонирхол, хандлагаа илэрхийлж байна. Энэхүү шаардлагыг хангахын тулд баталгаажсан ноолуурын нийлүүлэлтийг мөшгөх тогтолцоог нэвтрүүлэх загвар төслийг энэ жилээс Монголд хэрэгжүүлж байна. Ингэснээр ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламжтай холбоотой үнэн зөв мэдэгдэл бүхий эцсийн бэлэн бүтээгдэхүүнийг дэлхий зах зээлд гаргах тогтолцоо бүрдэнэ гэж харж байна. ТННЭ-ийн ноолуурын нийлүүлэлтийг мөшгөх баталгаажуулалтын схемүүд нь мал маллагаа, бэлчээр ашиглалт, ноолуур ханган нийлүүлэх, боловсруулах дамжлагыг баталгаатай, тогтвортой арга барилаар явуулж буйг малчны хотноос эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэл гэрчлэх үйл явцыг багтаасан тогтолцоо болно.

Одоогийн байдлаар загвар төслийн хүрээнд 70 гаруй тонн баталгаажсан түүхий ноолуурыг үндэсний 6 үйлдвэрүүдэд бэлтгэн нийлүүлсэн. Энэ ноолуураа боловсруулж, ТННЭ-ийн баталгаажсан ноолуурыг авах гадаадын худалдан авагчидтай холбох ажил хийгдэж байна. Дараа жилээс эхлүүлсэн энэ ажил маань тогтолцоо болоод явахад энэ жилийн ололт, амжилт, сургамж маш чухал үүрэгтэй. SFA-certified шошго худалдаанд гарна гэсэн үг, ийм маягаар тогтвортой арга ажиллагаагаар үйлдвэрлэсэн ноолуурын худалдаа борлуулалтыг нэмэгдүүлэх боломжтой.

Х.Хишигжаргал: ХХААЯ байсан бол энэ тал дээр санал хэлэх байсан болов уу, хэт олон байгууллага тус бүртээ жижиг стандарт боловсруулахыг дэмжихгүй бодлого баримталдаг гэж ойлгосон.

Д.Алтанцэцэг: Ихэнх тогтвортой ноолуурын төсөл малчдыг мөн бэлчээр хамраад байна. Үйлдвэрлэгчдийн түвшний төсөл цөөн байна. Бас олон төсөл, олон гэрчилгээжүүлэлт ярьж байгаа нь толгой эргүүлж байна. Чанарын баталгаажуулалт, тэмдэг гаргасан нь Хаан ширхэгт – малчны хотхоноос – бэлэн бүтээгдэхүүн. Энэ тал дээр нэгдсэн тэмдэг, гэрчилгээ хэрэгтэй байна.

Х.Хишигжаргал: Платформын зорилго яг тийм юм.

В.Шинэнэмэх: Цагалбараар төлөвлөгөөгөө танилцуулахад 5 сард удирдах хорооны хурлыг хийнэ, мөн Зөвлөх хороог байгуулаад хурлаа хийлээ. 6 сард хийх гол ажил бол платформын вэб сайтыг ажилд оруулаад мэдээллээ тавьсан байна. 6-9 сарын хугацаанд суурь судалгаанууд хийгдэнэ. 9 сард 2 судалгааны үр дүн гарсны дараа 10 сард албан ёсоор платформыг нээх үйл ажиллагааг төлөвлөж байна. Вэб сайт бэлэн болсны дараа бид нар soft launch буюу урьдчилсан байдлаар нээх нээлт явагдана. Нэгдсэн хуралдаанд 150-200 хүн

оролцох учраас одоохондоо хурал зохион байгуулах боломжгүй байна. 11-12 сард талууд хамтран хэрэгжүүлэх нэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг бүх талуудын оролцоотойгоор боловсруулж ирэх оны 1-р улиралд батлахад бэлэн болгоно. Удирдах хорооны гишүүдтэй бас нэг ярих асуудал бол Covid 19-тэй холбоотойгоор авах хариу арга хэмжээний хүрээнд 50,000 ам. доллар нэмж батлагдсан. Ийм учраас судалгаа, зөвлөх үйлчилгээ, хэвлэлд тавих нийтлэл зэрэг бэлэн төсөл байвал хамтраад хэрэгжүүлэх боломжтой. Энэ санхүүжилт нь энэ 2020 ондоо хэрэгжээд дуусгах ёстой байгаа. Тэгэхээр хамтран хэрэгжүүлэх төсөл байвал холбоо барина уу гэсэн хүсэж байна. Дүгнээд хэлэхэд, 2020 оны ажлын төлөвлөгөө, удирдамжийн эцсийн хувилбар, энэ презентацийг имэйлээр явуулна, саналаа тусгаад эргээд явуулна уу.

Х.Хишигжаргал: За баярлалаа. Covid 19-тэй холбоотойгоор авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг гаргаад Б.Батхүү даргад танилцуулсан. Хүнс, Хөдөө, аж ахуйн яамнаас 2 санал дэвшүүлсэн үүнд:

В.Шинэнэмэх: 1. Covid 19 ноолуурын салбарт том зургаараа ямар нөлөө үзүүлэх вэ? Олон улсын судалгааны байгууллагад хийгдсэн загвараар судалгаа хийгээд олон улсын бөгөөд дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр таниулах аян хийж болох уу гэсэн. Энэ тал дээр Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой уулзсан бөгөөд хамтран ажиллах боломжтой гэсэн.

2. Ямааг самнаж, ноолуур бэлтгэх үед мал их хэмжээгээр зовж, тарчилдаг гэсэн мессеж тархсан. Үүнийг шинжлэх ухааны аргачлалаар судалж, ямаа хэр их стрессд ордгийг хэмжиж, нотолгоонд суурилсан үр дүнтэй больё гэсэн хүсэлт ирсэн.

Х.Хишигжаргал: Саяны танилцуулсан 2 саналтай холбоотой санал байна уу?

Б.Батхишиг: Сайн дадал, бэлтгэн нийлүүлэлт, мал маллагаагаа зохистой хэрэгжүүлсэн гүйцэтгэлээр нь малчдын хоршоодыг урамшуулах ажлыг дэмжих ажлыг хийж болох уу? Энэхүү ажлыг хийснээр дараа дараагийн жилүүдэд малчдын хоршоодыг үнэлж, зөв дадлыг хэвшүүлснээр нь гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг дэмжих саналтай байна. Зохион байгуулалтад малчид орж, өөрсдөө асуудлыг шийдвэрлэх оролдлого хүчин чармайлт гаргаж байгааг үнэн зөвөөр үнэлэн урамшуулах арга хэмжээ дутагдаж байна. Зарим хоршоод малчдын жинхэнэ хоршоо биш зэргээр хоцорч үлдэх, гадуурхагдах тохиолдлууд ажиглагдаж байна.

В.Шинэнэмэх: Энэ санхүүжилт нь зөвлөх үйлчилгээ, сургалт байж болно, харин small grants байж болохгүй гэж заасан. Харин судалгаа нийтлэлд зарцуулах боломжтой юм.

А.Амгалан: Гүйцэтгэлд суурилсан урамшууллыг системийг ингэж нэвтрүүлэх боломжтой юм гэдгийг гаргаж ирэх зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээ байж болох уу. Сүүний салбарт чанарт суурилсан төлбөрийн системийг Монгол улсын нөхцөлд ийм хэлбэрээр нэвтрүүлж болох юм гэсэн зөвлөмж гаргуулсан туршлагаас харахад, иймэрхүү зөвлөмж байвал зүгээр гэж бодогдож байна. Улсаас жил бүр ноолуурын урамшуулал олгогддог. Энэ урамшуулалыг олгохдоо гүйцэтгэлд суурилсан буюу сайн дадал, тогтвортой мал маллагааны менежментийг хэрэгжүүлсэн гэдэг шалгуураар олгож болох юм.

Т.Булган: Гүйцэтгэлд суурилсан урамшууллыг нэвтрүүлэх чухал. Малчид өөрсдөө зохион байгуулалтанд ороод гүйцэтгэлээ яаж зөв талаас нь харуулах вэ гэсэн зөвлөх үйлчилгээ байж болох юм. Хэт олон судалгаа хийлээ гээд үр ашиг ямар вэ гэдэг дээр эргэлзэж байна. Яамны зүгээс энэ жил 5 жил тутамд хийдэг цөлжилтийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ хийгдэж байна. Тэр аргачлалыг шалгуур болгож авбал тохирч магадгүй. Нөгөө талаас, үйлдвэрлэгчдэд маш хэцүү байгааг ойлгож байгаа үүнтэй холбоотой бизнесийн ногоон зээлийг 3 банкаар дамжуулж 8 хувийн хүүтэй олгож эхэлсэн. Дулаан, халаалт, ариун цэврийн байгууламж зэргийг санхүүжүүлж болно. 7 сарын 31 хүртэл зээл олгогдож байна нөхцөл байдалтай холбоотойгоор сунгагдаж магадгүй – Үйлдвэрүүдэд мэдээлэл хүргэнэ үү.

В.Шинэнэмэх: “Талууд хамтран ажиллах төлөвлөгөө”-г бидний цаашид хийх ажлаас үүдэн гарах юм. Гадаадын зөвлөх баг үүн дээр туслаж ажиллана.

Х.Хишигжаргал: За ингээд удирдамжийн дагуу 2020 оны төлөвлөгөөг батлах байгаа 254,000 ам.доллар 2020 онд амжуулж дуусахыг хичээж ажиллаж байгаа, 5 сараас ажиллаж эхэлж байна. Дэмжиж байгаа бол гараа өргөнө үү. Хурлын бүх гишүүд гараа өргөн 2020 оны төлөвлөөө дэмжигдлээ. Гол үйл ажиллагааны чиглэлээр та бүхэнд санал байвал 7 хоногийн дотор саналаа өгөөрэй.

Д.Алтанцэцэг: Урьд нь ажлын хэсгийн гишүүдэд цалин өгөх тухай ярьж байсан. Багт ноос ноолуурын холбооноос орж ажиллах боломж байгаа юу? Цалин өгч эсвэл чадавхжуулах тал дээр туслаж чадах уу.

В.Шинэнэмэх: Өнөөдрийн хурлыг НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч өөрөө удирдсан, цаашдаа Орлогч суурин төлөөлөгч Нашида Саттар удирдана. Хамтран ажиллаж байгаа байгууллагын төлөөллүүд шууд чадавхжуулах сургалтад хамрагдаж болно гэсэн хариуг Николас зөвлөх өгсөн. Сургалтын цагуудыг төлөвлөөд чадавхижуулах сургалтыг хэзээ ч хамаагүй эхэлж болно гэсэн.

Х.Хишигжаргал: Чадавхижуулах сургалтыг зөвлөх баг GCP-гээс авж болно. Харин нэмэлт хүн авч баг ажилуулах төсөв байхгүй. Учир нь энэ жилийн төсвийг ENSURE төслөөс санхүүжүүлж байгаа бөгөөд удирдах хорооны хурлаар санхүүжүүлтийн төсвөө батлуулсан.

В.Шинэнэмэх: Ноолуурын шинэ төсөл хэрэгжиж эхэлвэл Платформд нэгдээд орох нээлттэй. Жишээ нь, ILO-гийн шинэ төсөл хэрэгжиж эхлэхээр бас нэг тал болон ажиллах боломжтой.

Д.Алтанцэцэг: Cashmere board гэж ерөнхийлөгчийн санаачлагаар байгуулбал яах вэ?

Ц.Эрдэнэбат: Болно. Ерөнхийлөгчийн дэргэд эдийн засгийн үндэсний хороо байгуулагдана. Ноолуурыг дэмжих хороотой ойролцоо бүтэцтэй байгуулагдаж байна (энэ асуудлаар харилцан хэлэлцэв, хурлын тэмдэглэлд оруулах шаардлагатай гэж үзвэл нэмж оруулна уу).

Шийдвэр:

1. Гишүүдийн гаргасан саналыг тусгасан Удирдах Хорооны ажлын удирдамж, Платформын 2020 оны ажлын төлөвлөгөөний дэлгэрэнгүй хувилбар, хурал дээр танилцуулсан илтгэлийг имэйлээр илгээнэ. Гишүүд 1 долоо хоногийн дотор танилцаж, шаардлагатай баримт бичгийг батлана
2. Платформын ажлын хэсгээс Удирдах Хорооны гишүүдийн имэйл групп нээх, гишүүдийг урих, мэдээлэл санал солилцох хэрэгсэл болгож ашиглах
3. Гишүүн байгууллага тус бүр дээр Ковид 19-той холбоотой хийгдсэн судалгаа, үнэлгээний тайлан, үр дүнг хуваалцахаар тохиров (UNDP, FAO, SFA).

Батлав:

……. Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч

Тэмдэглэл хөтөлсөн:

..... В.Шинэнэмэх, Платформын Менежер

Хянасан:

..... Х.Хишигжаргал, НҮБХХ-ийн шинжээч